

**"УЛААНБААТАР БҮК"ХК-ИЙН ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН 2023 ОНД  
ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

Тайлагнах хугацаа	2023.01.01-2023.12.31
Тайлан гаргасан	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Байршальмаа

Тайланг хянаж баталсан : ТУЗ-ийн дарга Д.Нямхүү:.....

№	1.Компанийн засаглалын бодлого, үйл ажиллагаа
1	Компанийн засаглалын шинэтгэлийн хүрээнд ТУЗ болон удирдлагын багт шинэтгэлийн талаар мэдээлэл хүргүүлэх, эдгээр шинэтгэлүүдийг компани дээр хэрэгжүүлэх арга боломжийн талаар тухай бүр зөвлөмж өгч ажиллав. Ингэснээр ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны журамд "эрсдлийн" талаарх чиг үүргийг нэмэлтээр оруулан "Аудит, эрсдлийн хороо" болгон журмыг өөрчилж батлуулав. Мөн "Эрсдлийн удирдлагын бодлого", "Комплаенсын хяналтын заавар", "Дотоод аудиторын дүрэм", "Комплайнсын хяналтын заавар", "Бизнесийн ёс зүй", "Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого"-ын төслүүдэд ТУЗ-ийн гишүүдээс санал авч ТУЗ-д танилцуулан санал авч батлуулав. /Компанийн сайтад байршуулсан/
2	ТУЗ-ийн гишүүдийн сургалтын төлөвлөгөөний дагуу "Эрсдлийн менежмент", Засаглалын менежменттэй холбоотой сургалтуудыг бэлтгэн ТУЗ-гишүүдэд мэдээлэл өгч төстээр мэдлэгийн түвшинг тогтоох ажлыг зохион байгуулсан ба дундаж түвшин 98%-тай байна.
2.Хувьцаа эзэмшигчдийн хурал,	
3	2023 оны ээлжит ХЭХ-ын бэлтгэл ажлыг хууль дүрмийн дагуу зохион байгуулж Компанийн хувьцаа эзэмшигчдэд брокер диллерийн компаниудаар дамжуулан хурлаар хэлэлцэх асуудлаарх мэдээллийг бэлтгэн хүргүүлэх, зар мэдээг хөрөнгийн бирж, болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлах зэрэг арга хэмжээ авч ажилласан.Ээлжит ХЭХ-ын хуралд 2 асуудал танилцуулж, 3 асуудал хэлэлцүүлж 3 тогтоол батлагдсан. ХЭХ-тай холбоотой 151 хуудас баримт материалыг баталгаажуулан СЗХ, Хөрөнгийн биржид тогтоосон хугацаанд хүргүүлж холбогдох дүгнэлт, зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлж ажиллаж байна.
3.Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурал, Хороодын хурал	
4	"Улаанбаатар БҮК"ХК-ийн ТУЗ-ийн хурлыг батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулж, хэлэлцэх асуудлын хүрээнд холбогдох мэдээллүүдийг орос монгол хэл дээр бэлтгэн 5 удаа ердийн, 2 удаа эчнээ байдлаар зохион байгуулсан ба 22 асуудал хэлэлцсэний үр дүнд 3 эчнээ шийдвэр гарч 15 тогтоол баталсан байна. ТУЗ-ийн дэргэдэх Аудит, эрсдлийн хорооны 2 удаагийн хурлын бэлтгэл ажлыг зохион байгуулснаар "НББ бодлогын бичиг баримт", "Дотоод аудиторын дүрэм"-ийн талаар шийдвэр гаргаж ТУЗ-аар хэлэлцүүлж баталсан. Нэр дэвшүүлэх хорооны 2 удаагийн хурлын бэлтгэл ажлыг зохион байгуулснаар ТУЗ-д нэр дэвшүүлэх шийдвэрийг баталж ээлжит ХЭХ-д хэлэлцүүлэх арга хэмжээ авсан мөн түүнчлэн "ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга, эрх бүхий албан тушаалтнуудын ажлын үр дүнг үнэлэх журам"-ыг хэлэлцүүлэн ТУЗ-д танилцуулж батлуулах арга хэмжээ авсан болно.

<b>4.Хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт, тайлан</b>	
5	Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан “ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ЖУРАМ” –ын дагуу Улаанбаатар БҮК”ХК-ийн үйл ажиллагааны тайланг бэлтгэн журамд заасан хугацаанд хагас, бүтэн жилээр СЗХ,МХБ-д хүргүүлж, мэдээллийг компанийн сайтад нийтэлж олон нийтэд мэдээлэх арга хэмжээ авч ажиллав.
6	2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор баталсан “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ын дагуу Кодексын хэрэгжилтийн тайлан, үнэлгээг хагас бүтэн жилээр 9 зарчим, 36 асуудлын хүрээнд боловсруулж мэдээлэл бэлтгэн СЗХ,МХБ-д хүргүүлж, мэдээллийг компанийн сайтад нийтэлж олон нийтэд мэдээлэх арга хэмжээ авч ажиллав.
7	"МХБ"-ээс баталсан “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам”-ын 12 төрлийн мэдээллийг бэлтгэн хагас жил,бүтэн жилээр МХБ-ийн сайтад оруулан нийтэд мэдээлэх арга хэмжээ авч ажиллаж байна.
8	"Компанийн засаглал"-ын кодексын талаарх мэдээллийг тухай бүр ТУЗ-д танилцуулж ажилласнаар Хороодын дарга нарыг "Хараат бус" гишүүнээр томилох асуудлыг ТУЗ баталсан.
<b>4.ТУЗ-ийн тогтоол шийдвэрийн хэрэгжилт</b>	
9	ТУЗ, хороодоос гаргасан тогтоол шийдвэрүүдийг Компанийн дотоод хяналтын албанд тухай бүр баталгаажуулан хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажилласнаар Гүйцэтгэх захиралд өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн биелэлт 95%-тай байна.
<b>5.Компанийн бичиг баримтын бүрдэл, бүртгэл, хадгалалт</b>	
10	ТУЗ-өөс баталсан тогтоол, хурлын баримтуудыг баталгаажуулан бүртгэл хөтлөн 10 жилийн хугацааны дата үүсгэн шаардлагатай асуудлаар дүн шинжилгээ дүгнэлт гарган ТУЗ-д танилцуулж ажилласан. Баримтуудыг цахим архив үүсгэн хадгалах, эрх бүхий албан тушаалтны шаардлагаар танилцуулах арга хэмжээ авсан ба 5 жил болсон 2018 оны баримт бичгүүдийг архивт шилжүүлсэн.